



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/15

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Түнэл сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус цэцэрлэгт улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 37,985,800 (Гучин долоон сая есөн зуун наян таван мянга найман зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 7,068,400 (Долоон сая жаран найман мянга дөрвөн зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, 3,837,000 (Гурван сая найман зуун гучин долоон мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий нормын хувцас, зөөлөн эдлэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, тус сумын эмнэлэгт улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 4,499,900 (Дөрвөн сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Түнэл сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Б.Эрдэнэцэцэг), Эрүүл мэндийн төвийн дарга (И.Өлзийбадрах) нарт тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Л.ГАНБОЛД

01110008

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 15 -ны өдрийн А/15 дугаар  
захирамжийн 01 дүгээр хавсралт




ТҮНЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХООЛ, ХҮНСНИЙ  
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-37,985,800 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн  
Ч.Эрдэнэчимэг-"Ойн цэцэрлэг" ХХК-ийн захирал  
Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 15 -ны өдрийн А/15 дугаар  
захирамжийн 02 дугаар хавсралт



ТҮНЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ БҮТЭЗ, НОРМЫН  
ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-10,905,400 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ч.Эрдэнэчимэг-"Ойн цэцэрлэг" ХХК-ийн захирал

Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр  
сарын 15 -ны өдрийн А/15 дугаар  
захирамжийн 03 дугаар хавсралт



ТҮНЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ШАТАХ, ТОСЛОХ  
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН  
(Төсөвт өртөг-4,499,900 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн  
Ч.Эрдэнэчимэг-"Ойн цэцэрлэг" ХХК-ийн захирал  
Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: А.Цэрэндулам-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга